

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2021 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
11 ДҮГЭЭР САРЫН 11-НИЙ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ**

№	Баримтын агуулга	Хуудас
	Хуралдааны товч тэмдэглэл:	1-33
	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	34-129
	1.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2021.09.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/	39-42 94-104
	2.Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.10.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	42-50
	3.“Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2021.10.06-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	50-51
	4.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2022 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2023-2024 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2021.09.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	51-53
	5.Монгол Улсын 2022 оны төсвийн тухай, Нийгмийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2022 оны төсвийн тухай, Ирээдүйн өв сангийн 2022 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2021.09.30-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	53-65
	6. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	65-66
	7.Боловсролын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл /Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	66-71
	8.“Тогтоолд өөрчлөлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	71-72
	9.“Авлигатай тэмцэх газрын албан тушаалын цалингийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Монгол Улсын 2022 оны төсвийн төсөлтэй холбогдуулан боловсруулсан, анхны хэлэлцүүлэг/	72-73
	10.Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	73-94, 104-116
	11.Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/	116-129

Хураангуй тэмдэглэл

Арван нэг.Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2021.05.19-ний өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.Баасандорж, мөн яамны Хууль зүйн бодлогын газрын дарга П.Сайнзориг, мөн газрын ахлах мэргэжилтэн Ж.Амгалан, шинжээч Х.Сүрэнхорол, Мэдээллийн технологийн газрын дарга Д.Ган-Эрдэнэ, Тагнуулын ерөнхий газрын Мэдээллийн аюулгүй байдлын газрын дарга Э.Эрдэнэ, мөн газрын Мэдээллийн аюулгүй байдлын албаны дарга Д.Ганзориг, Харилцаа холбоо, мэдээллийн технологийн газрын дарга Б.Болор-Эрдэнэ, мөн газрын Мэдээллийн технологийн бодлого зохицуулалтын газрын дарга Б.Билэгдэмбэрэл, Цахим

хөгжлийн үндэсний хорооны Ажлын албаны дарга С.Тэнгис, Мэдээллийн холбооны операторуудын ассоциацийн гүйцэтгэх захирал У.Тамир нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга О.Номинчимэг, Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, мөн хэлтсийн референт Г.Алтанцэцэг, Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх П.Батбаатар, референт Б.Золбоо, Ёс зүй, сахилга хариуцлагын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Х.Энэбиш, Хяналт шалгалт, үнэлгээний газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч С.Янжинхорлоо нар байлцав.

Төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Н.Учрал танилцуулав.

Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт гараагүй болно.

Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг.Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн санал:

Г.Занданшатар: 1.Улсын Их Хурлын гишүүн Н.Учрал, Н.Алтанхуяг, П.Анужин, Э.Бат-Амгалан, Т.Доржханд, Л.Мөнхбаатар, Б.Саранчимэг, Ж.Сүхбаатар, Д.Цогтбаатар /цаашид “Ажлын хэсэг” гэх/, Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “нийтийн мэдээллийн дэд бүтцийг бий болгох замаар” гэснийг “нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох,” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 16
Бүгд: 40
60.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “цахим баримт бичиг, нийтийн”, “дамжуулах,” гэснийг, 4.1.5 дахь заалтын “хүн, эсхүл техник хэрэгсэл, программ хангамжийн тусламжтайгаар” гэснийг, 4.1.11 дэх заалтын “цахим” гэснийг болон 4.1.9, 4.1.10 дахь заалтыг тус тус хасаж, 4.1.1 дэх заалтын “программ” гэсний дараа “хангамж,” гэж нэмж, 4.1.2 дахь заалтын “суваг, техник хэрэгсэл болон программ хангамжийн” гэснийг “программ хангамж болон техник хэрэгслийн” гэж, 4.1.3 дахь заалтын “4.1.5-д заасан этгээд болон хуулийн этгээдийн” гэснийг “4.1.6-д заасан хүн болон тухайн” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22

Татгалзсан: 18
Бүгд: 40
55.0 хувийн саналаар дэмжигдлээ.

3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.7 дахь заалтын “нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан” гэсний өмнө “нийтийн мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа, эсхүл” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39
53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын дэд дарга С.Одонтуяа 15 цаг 51 минутаас хуралдааныг даргалав.

С.Одонтуяа: 4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн “бөгөөд төрийн нууцад үл хамаарах” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39
56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.9 дэх заалтын “үйл ажиллагааны чиглэлээрх салбарын нэгтгэн боловсруулсан” гэснийг “салбарын үйл ажиллагааны” гэж өөрчилж, 8.6.20 дахь заалтын “мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн,” гэсний дараа “, гэрээний хэрэгжилт” гэж, 8.7 дахь хэсгийн “энэ хуулийн 8.6.14-т заасан мэдээллийг Улсын дээд шүүх,” гэсний дараа “энэ хуулийн 8.6.15-д заасан мэдээллийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц,” гэж тус тус нэмж, 8.14 дэх хэсгийн “цахим хуудас хариуцсан ажилтан” гэснийг хасч, 8.6.17 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 8.6.18 дахь заалт болгох:

“8.6.18.зүй ёсны монополь аж ахуй эрхлэгчийн үнийн бүрдлийн мэдээлэл болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийн жагсаалт;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 23
Татгалзсан: 16
Бүгд: 39
59.0 хувийн саналаар дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн “харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, “харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн

газрын гишүүн” гэж тохиолдол бүрд агуулгад нь тохируулан тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалтын “мэдээлэл авагчийн нэр” гэснийг “мэдээлэл авагч нь хувь хүн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр” гэж, 9.6.8 дахь заалтын “зөвшөөрлөө цуцлах нөхцөл” гэснийг “зөвшөөрлөө цуцлах хэлбэр” гэж тус тус өөрчилж, 9.6.4, 9.17.2 дахь заалтын “агуулга,” гэснийг болон 9.2.4, 9.2.5 дахь заалтыг тус тус хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, М.Оюунчимэг, Н.Учрал нар үг хэлэв.

Зөвшөөрсөн: 21
Татгалзсан: 18
Бүгд: 39

53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийн “Хуульд өөрөөр заагаагүй бол” гэснийг, 18.14 дэх хэсгийн “цахим хэлбэрээр” гэснийг тус тус хасаж, 18.16 дахь хэсгийн “гэрээний загвар,” гэсний дараа “зардал тооцох аргачлал,” гэж нэмж, 18.12 дахь хэсгийн “үндсэн системд холбогдсон мэдээллийн сангаас” гэснийг “үндсэн системээр дамжуулан” гэж 18.14, 18.15 дахь хэсгийн “үндсэн систем” гэснийг “үндсэн болон дэмжих систем” гэж тус тус өөрчилж, 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18.2 дахь хэсэг нэмэх:

“18.2.Энэ хуульд заасан үндсэн систем, дэмжих систем, мэдээлэл хариуцагчийн систем нь нийтийн мэдээллийн системд хамаарна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн М.Оюунчимэг үг хэлэв.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 15
Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

9.Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатарын гаргасан, Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “Нийтийн мэдээллийн системээр” гэснийг “Үндсэн системээр” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 22
Татгалзсан: 17
Бүгд: 39

56.4 хувийн саналаар дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг хасаж, 24.4 дэх хэсгийн “нэгдсэн системээс” гэснийг “нэгдсэн системээр дамжуулан мэдээлэл хариуцагчаас” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 15

Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “Нийтийн мэдээллийн системийн” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24

Татгалзсан: 15

Бүгд: 39

61.5 хувийн саналаар дэмжигдлээ.

12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.10.Цахим хэлбэрээр үүсгэх нийтийн мэдээллийн сан нь нэгдсэн ангилал, код, тайлбартай байна.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 15

Бүгд: 41

63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “албан харилцаанд” гэснийг “хуульд заасан чиг үүргийн хүрээнд” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 14

Бүгд: 41

65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 32 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27

Татгалзсан: 14

Бүгд: 41

65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “33.1.15-д” гэснийг “33.1.4, 33.1.13, 33.1.14, 33.1.15, 33.1.16, 33.1.18-д” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.5.3 дахь заалтын “түүхчилсэн бичлэг /лог/ үүсгэх” гэснийг “үйлдлийн бүртгэл үүсгэх” гэж өөрчилж, 34.5.4 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалтын “нээлттэй өгөгдлийн нэгдсэн порталд” гэснийг “нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд” гэж өөрчилж, 35.1.8 дахь заалтын “өөрийн чиг үүрэгт хамаарах үйлчилгээг” гэсний дараа “цахим хэлбэрээр болон” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “2022 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор” гэснийг “2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор” гэж өөрчилж, 38.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.1.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө нийтийн мэдээллийн системийг ашиглан үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээд цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хугацаанд энэ хуульд заасан шаардлагыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэснийг “2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 26

Татгалзсан: 15
Бүгд: 41
63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 24
Татгалзсан: 17
Бүгд: 41
58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хоёр.Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал:

С.Одонтуяа: Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, С.Бямбацогт, Ц.Мөнхцэцэг нарын гаргасан, Төслийн нэрийг “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” гэж өөрчлөх гэсэн Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 12
Татгалзсан: 29
Бүгд: 41
29.3 хувийн саналаар Байнгын хорооны санал дэмжигдсэнгүй.

Гурав.Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн найруулгын санал:

С.Одонтуяа: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтын “мэдээллийн системийн тусламжтайгаар” гэснийг “мэдээллийн системийг ашиглан” гэж, 8 дугаар зүйлийн 8.2.2 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.6.2, 9.6.3 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтын “харилцах утас” гэснийг “харилцах утасны дугаар” гэж, 8 дугаар зүйлийн 8.2.10 дахь заалтын “зохион явуулах” гэснийг “зохион байгуулах” гэж, 8.4.14 дэх заалтын “олон улсын байгууллагаас авах зээл” гэснийг “олон улсын байгууллагаас авсан зээл” гэж, 9.15 дахь хэсгийн “баталгаа” гэснийг “баталгаажуулалт” гэж, 9 дүгээр зүйлийн 9.17 дахь хэсгийн “үйл ажиллагааны болон” гэснийг “үйл ажиллагаа,” гэж, 36 дугаар зүйлийн 36.2.5 дахь заалтын “нэвтрэлт хийгдсэн” гэснийг “нэвтэрсэн” гэж тус тус өөрчлөх.

2.Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалтын “мэдээлэл хариуцагч,” гэснийг хасах.

3.Төслийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсгийн “ил тод, нээлттэй” гэсний өмнө “байнга” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтын “соёлын хосгүй” гэсний дараа “үнэт” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “холбогдсон харилцааг” гэсний дараа “тухайлсан” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 14
Бүгд: 41
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан саналын томьёоллоор санал хураалт явуулав.

**Нэг.Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны
дэмжсэн санал:**

С.Одонтуяа: 1.Ажлын хэсгийн гаргасан, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1, 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1 дүгээр зүйл.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын “Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.4-т заасныг” гэснийг “Нийтийн мэдээллийн тухай хуулийн 4.1.9-д заасныг” гэж, 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийн “мөрдөнө.” гэснийг “мөрдөж болно” гэж, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “тоон гарын үсгээр” гэснийг “цахим гарын үсэг, эсхүл давтагдашгүй дугаараар” гэж тус тус өөрчилсүгэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 25
Татгалзсан: 16
Бүгд: 41
61.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн “15.33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хязгаарлалттай мэдээллийг” гэсний өмнө “Албаны нууцаас бусад” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 27
Татгалзсан: 14
Бүгд: 41
65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Чуулганы нэгдсэн хуралдаанаар 11 асуудал хэлэлцэв.

Бусад.Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалангийн урилгаар “Монгол Улсад орчин цагийн боловсролын тогтолцоо үүсэж хөгжсөний 100 жилийн ойн баяр”-ыг тэмдэглэх арга хэмжээний хүрээнд аймаг,

нийслэл, дүүргийн Боловсролын газар, хэлтсүүдийн дарга болон багш нарын төлөөлөл Төрийн ордон, Улсын Их Хурлын чуулганы үйл ажиллагаатай танилцав.

Улсын Их Хурлын дарга Г.Занданшатар 11 дүгээр сарын 09-ний өдөр төрсөн өдөр нь тохиосон Улсын Их Хурлын гишүүн Цэндийн Сандаг-Очир, 11 дүгээр сарын 11-ний өдөр төрсөн өдөр нь тохиож байгаа Улсын Их Хурлын гишүүн Нанзадын Наранбаатар нарт Улсын Их Хурлын гишүүдийн нэрийн өмнөөс баяр хүргэж, эрүүл энх, аз жаргал, сайн сайхныг хүсэн ерөөв.

Чуулганы нэгдсэн хуралдааны зохион байгуулалтыг Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Хуралдаан зохион байгуулах хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн шинжээч М.Номиндулам, С.Энхзаяа нар болон техник хангамжийн зохион байгуулалтыг Мэдээллийн технологийн хэлтсийн дарга Ж.Элбэгзаяа, шинжээч У.Энхжин нар хариуцан ажиллав.

Хуралдаан 5 цаг 39 минут үргэлжилж, 76 гишүүнээс 62 гишүүн хүрэлцэн ирж, 81.5 хувийн ирцтэйгээр 16 цаг 30 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

Л.ӨЛЗИЙСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА

Дэлгэрэнгүй тэмдэглэл

Дараагийн асуудалд орно. Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооноос гаргасан хамтарсан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн, Инновац, цахим бодлогын байнгын хорооны дарга Н.Учрал танилцуулна.

Н.Учрал: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас 2021 оны 5 дугаар сарын 19-ний өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Нийтийн мэдээллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Улсын Их Хурал 2021 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж, анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлсэн билээ.

Улсын Их Хурлын даргын 2021 оны 7 дугаар сарын 06-ны өдрийн 54 дүгээр захирамжаар Улсын Их Хурлын гишүүн Н.Учралаар ахлуулан, гишүүдэд Н.Алтанхуяг, П.Анужин, Э.Бат-Амгалан, Т.Доржханд, Л.Мөнхбаатар, Б.Саранчимэг, Ж.Сүхбаатар, Д.Цогтбаатар нарын бүрэлдэхүүнтэйгээр хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл хангах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулж, ажлын хэсэгт мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, мэдээллээр хангах дэд ажлын хэсэгт холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан ажилласан болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.4 дэх хэсэгт заасны дагуу Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хороо 2021 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн хамтарсан хуралдаанаараа дээрх хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулж, хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцлээ.

Ажлын хэсгээс хуулийн төсөлтэй холбогдуулан нийтийн мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа мэдээллийг хүн, хуулийн этгээдээс шаардахгүй байх талаар, мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлаас гадна гэрээний хэрэгжилтийг нээлттэй, ил тод байлгахгаар, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу маргаан хянан шийдвэрлэсэн ажиллагааны дүн мэдээг Үндсэн хуулийн цэц хариуцаж байнга, ил тод, нээлттэй байлгахгаар, мэдээлэл хариуцагчаас бусад хуулийн этгээд иргэнд үйлчилгээ үзүүлэхдээ үндсэн болон дэмжих системийг ашиглаж болох бөгөөд энэ тохиолдолд зардал тооцох аргачлалыг Засгийн газар батлахаар, Монгол Улсын Засгийн газрын бүтцийн тухай хуулийн нэмэлт, өөрчлөлттэй нийцүүлэн Харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагыг Цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болгох талаар нийт 19 зарчмын зөрүүтэй санал, 1 найруулгын санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Түүнчлэн ажлын хэсгээс Нийтийн мэдээллийн тухай хуулийн шинэчилсэн

найруулгын төслийн хамт өргөн мэдүүлсэн Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй 2 санал, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй 1 санал боловсруулсныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн болно.

Хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулах үед Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар Нийтийн мэдээллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “Нийтийн мэдээллийн системээр” гэснийг “Үндсэн системээр” гэж өөрчлөх зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн.

Мөн Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, С.Бямбацогт, Ц.Мөнхцэцэг нараас хуулийн төслийн нэрийг “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” гэж өөрчлөх зарчмын зөрүүтэй санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй тул Улсын Их Хурлын гишүүн С.Бямбацогт уг асуудлаар цөөнх болж, нэгдсэн хуралдаанд үг хэлж саналаа тайлбарлан санал хураалгахаа илэрхийлсэн болно.

Түүнчлэн Улсын Их Хурлын гишүүн Н.Алтанхуяг, Ц.Мөнхцэцэг, Д.Ганбат, Б.Энх-Амгалан, Ч.Ундрам нар хуулийн төсөл болон зарчмын зөрүүтэй саналын томьёололтой холбогдуулан асуулт асууж, хариулт авлаа.

Байнгын хороо ажлын хэсэг болон Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг нэг бүрчлэн хэлэлцсэн бөгөөд олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн бэлдсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол болон хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг Та бүхэнд тараасан болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Нийтийн мэдээллийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулсан талаарх Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны хамтарсан санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналыг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Баярлалаа.

Г.Занданшатар: Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух гишүүд байна уу? Алга байна.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн саналаар санал хураалт явуулъя.

Нийтийн мэдээллийн тухай хууль Шинэчилсэн найруулгын талаарх санал.

Төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн “нийтийн мэдээллийн дэд бүтцийг бий болгох замаар” гэснийг “нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох,” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ням-Осорын Учрал, Норовын Алтанхуяг, Пүрэв-Очирын Анужин, Энхтайваны Бат-Амгалан, Тогмидын Доржханд, Лхагвын Мөнхбаатар, Батсүхийн Саранчимэг, Жамъянхорлоогийн Сүхбаатар /цаашид “Ажлын хэсэг” гэх/.

Дамдины Цогтбаатар гишүүн энд байсан яагаад хурал эхлэнгүүт гараад явчихсан уу?

Санал хураалт.

24 гишүүн дэмжиж, 60 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

2.Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтын “цахим баримт бичиг, нийтийн”, “дамжуулах,” гэснийг, 4.1.5 дахь заалтын “хүн, эсхүл техник хэрэгсэл, программ хангамжийн тусламжтайгаар” гэснийг, 4.1.11 дэх заалтын “цахим” гэснийг болон 4.1.9, 4.1.10 дахь заалтыг тус тус хасаж, 4.1.1 дэх заалтын “программ” гэсний дараа “хангамж,” гэж нэмж, 4.1.2 дахь заалтын “суваг, техник хэрэгсэл болон программ хангамжийн” гэснийг “программ хангамж болон техник хэрэгслийн” гэж, 4.1.3 дахь заалтын “4.1.5-д заасан этгээд болон хуулийн этгээдийн” гэснийг “4.1.6-д заасан хүн болон тухайн” гэж тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Санал хураалтад 40 гишүүн оролцож, 22 гишүүн дэмжиж, 55 хувийн саналаар энэ санал дэмжигдлээ.

3.Төслийн 5 дугаар зүйлийн 5.1.7 дахь заалтын “нийтийн мэдээллийн дэд бүтцийг ашиглан” гэсний өмнө “нийтийн мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа, эсхүл” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

С.Одонтуяа: 21 хүн дэмжиж, 53.8 хувиар санал дэмжигдлээ.

Төслийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн “бөгөөд төрийн нууцад үл хамаарах” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

22 хүн санал хураалтад оролцож, 56.4 хувиар дэмжигдлээ.

5.Төслийн 8 дугаар зүйлийн 8.2.9 дэх заалтын “үйл ажиллагааны чиглэлээрх салбарын нэгтгэн боловсруулсан” гэснийг “салбарын үйл ажиллагааны” гэж өөрчилж, 8.6.20 дахь заалтын “мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн,” гэсний дараа “, гэрээний хэрэгжилт” гэж, 8.7 дахь хэсгийн “энэ хуулийн 8.6.14-т заасан мэдээллийг Улсын дээд шүүх,” гэсний дараа “энэ хуулийн 8.6.15-д заасан мэдээллийг Монгол Улсын Үндсэн хуулийн цэц,” гэж тус тус нэмж,

8.14 дэх хэсгийн “цахим хуудас хариуцсан ажилтан” гэснийг хасч, 8.6.17 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулж 8.6.18 дахь заалт болгох:

“8.6.18.зүй ёсны монополь аж ахуй эрхлэгчийн үнийн бүрдлийн мэдээлэл болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчийн жагсаалт;” Санал гаргасан ажлын хэсэг.

23 хүн саналд оролцож, 59 хувиар дэмжигдлээ.

6.Төслийн “харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага” гэснийг “цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага” гэж, “харилцаа холбоо, мэдээллийн технологийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэснийг “цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн” гэж тохиолдол бүрд агуулгад нь тохируулан тус тус өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Санал хураалтыг 21 гишүүн дэмжиж, 61.5 хувиар санал дэмжигдлээ.

7.Төслийн 9 дүгээр зүйлийн 9.6.2 дахь заалтын “мэдээлэл авагчийн нэр” гэснийг “мэдээлэл авагч нь хувь хүн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, хуулийн этгээд бол хуулийн этгээдийн нэр” гэж, 9.6.8 дахь заалтын “зөвшөөрлөө цуцлах нөхцөл” гэснийг “зөвшөөрлөө цуцлах хэлбэр” гэж тус тус өөрчилж, 9.6.4, 9.17.2 дахь заалтын “агуулга,” гэснийг болон 9.2.4, 9.2.5 дахь заалтыг тус тус хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Мөнхцэцэг гишүүн энэ санал дээр үг хэлнэ.

Ц.Мөнхцэцэг: Засгийн газраас өргөн барьсан нийтийн мэдээллийн тухай хууль бол иргэдийн мэдээлэл олж авахад төрийн мэдээллийг ил тод болгох чиглэлээр маш томоохон дэвшил гаргаж байгаа хууль. Гэтэл энэ хуулийн 9 дүгээр зүйл буюу одоо энэ хаалттай мэдээлэл гэж оруулсан энэ бүлэг бол тэр чигээрээ хуулийн одоо үндсэн үзэл баримтлалтай нийцэхгүй. Ухралт хийж байгаа энэ асуудал байна. Тийм учраас энэ үндэслэлийг би бол гурван үндэслэлээр эсэргүүцэж байгаа. Энэ тухай Хууль зүйн байнгын хороон дээр бас цөөнх болж байр сууриа илэрхийлсэн байгаа. Хязгаарлалттай мэдээлэл гэдэг маань одоо тухайн мэдээллийн эзний зөвшөөрлөөр олж авдаг тэгээд ямар ч үед тухайн мэдээлэл өгсөн иргэн маань өгсөн зөвшөөрлөө цуцлах бүхий ийм ноцтой хаалт учруулж байгаа нууцлал бүхий ийм мэдээллийн төрөл болж байна. Урд өмнөх мэдээллийн тухай хуулиуд дээр ийм ангилал байгаагүй. Тэгээд энэ хязгаарлалттай мэдээлэл гэж 9 дүгээр зүйл маань гурван үндэслэлээр Монгол Улсын Үндсэн хууль болон хүний одоо мэдээлэл олж авах эрхийг зөрчиж байгаа.

С.Одонтуяа: Мөнхцэцэг гишүүний минутыг нэмж өгье.

Ц.Мөнхцэцэг: Тэгэхээр ямар гурван үйлдлээр зөрчиж байна гэхээр ер нь одоо төрийн зүгээс төрийн одоо мэдээллээ өгч байгаа албан тушаалтан мэдээллийг ил тод байлгах ёстой нууцлагдмал мэдээллийг зөвхөн үндэсний эрх ашигт аюул занал учруулах ийм тохиолдолд нууцлахаар бол заасан байдаг. Энийг одоо зөрчиж байна.

Хоёрдугаарт нь Монгол Улсын Үндсэн хуулийн 16.17- дээр төрийн одоо нууцлах мэдээллийг зөвхөн хуулийн хүрээнд заана гэж заасан. Гэтэл энэ одоо 9 дүгээр зүйлийн энэ зүйлээр үзэхээр тухайн мэдээлэл хариуцагч албан тушаалтны үзэмжээр тухайн хэсэг мэдээллийг одоо хаалттай хязгаарлах боломжийг олгож байна. Тийм учраас энэ заалт бол Үндсэн хууль зөрчиж байгаа.

Гуравдугаарт нь одоо ер нь мэдээлэл хүсэгч иргэн маань тухайн хаалттай мэдээллийг олж авахын тулд үндэслэл зорилгоо тавьдаг ямар байдлаар хэрэглэгдэж байгаа гэдгээ тайлбарлах ёстой. Энэ маань одоо мэдэх эрх иргэний мэдээлэл олж авах эрх тэр дотроо сэтгүүлчдийг мэдээлэл олж авахад сөргөөр нөлөөлсөн ийм заалт учраас энэ заалтыг бол тэр чигээр нь эсэргүүцэж хуулиас бол авах нь зүйтэй гэж үзэж байгаа. Тэгээд Хууль зүйн байнгын хороон дээр ярьсан боловч цөөнх болсон байна.

С.Одонтуяа: Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн санал хэллээ. Оюунчимэг гишүүн санал хэлье. Учрал гишүүн байгаа юм байна.

М.Оюунчимэг: Сая Мөнхцэцэг гишүүний хэлж байгааг бол үнэхээр бас анхаарах ёстой ноцтой асуудал. Яг мэргэжлийн сэтгүүлчдийн мэдээлэл авах эрхэд хэрвээ энэ хуулиар хаалттай ойлгомжгүй ийм хаалт оруулаад өгсөн бол дараа нь энэ хуулиа барих уу, эсвэл нөгөө хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулиа барих уу гээд манай хуулиуд чинь нэг нь нөгөөгөө үгүйсгэдэг тийм заалтууд байгаад байгаа шүү дээ.

Хэрвээ 9 дээр үнэхээр хаалттай мэдээлэл гэдэг дээр ямар мэдээлэл эхэлж байгаа юм. Энэ нь өөрөө хэвлэн мэдээлэх эрх чөлөөнд юм уу, Тэр сэтгүүлчийн эрхэд халдсан заалт давхардсан маягаар ороод өгчхөөр энэ чинь тухайн сэтгүүлч үүргээ биелүүлснийхээ төлөө асуудалд орох нөхцөл үүсэхвийдээ. Яг тийм юм байгаа юм уу. Энэ дээр би нэг тодорхой хариулт авмаар байна. Хэрвээ тийм бол сая гишүүний хэлсэнчлэн энийг бид яав ч дэмжиж болохгүй. Ийм ухралт хийж болохгүй. Тэгэхээр хамгаалахдаа хаалттай мэдээлэл гэдгээр яг юу хэлж байгаа юм. Энэ дээр нэг тодорхой хариулт өгөөч.

С.Одонтуяа: Хэн хариулах вэ? Микрофонухоо дугаарыг.

Учрал гишүүн хариулъя.

Н.Учрал: Энэ нийтийн мэдээллийн хууль бол ямар ч мэдээллийг хориглоод хаагаад байгаа хууль ерөөсөө биш шүү. Буруу ойлголт бол бас өгч болохгүй ээ. Тэр 2016 оны төрийн болон албаны нууцын хууль дээр чинь албаны нууц гээд тамга дарчхаад төрийн байгууллага мэдээллийг нууцлаад байна гэж шүүмжлэлтэй байсан. Энэ хуулиар бол нийтийн мэдээллийн хуульдаа мэдээллүүдийг нээлттэй хязгаартай хаалттай хуваагаад 5 багц 67 мэдээллийг олон нийтэд нээлттэй болгож байгаа. Нөгөө лицензүүдийг нь тусгай зөвшөөрөл эзэмшиж байгаа гэрчилгээг чинь

хэн эзэмшиж байна тэр тусгай хамгаалалттай газрыг чинь хэн эзэмшиж байна. Бүх зүйл одоо энэ 67 мэдээлэл бүгдээрээ нээлттэй. Үүнээс гадна нээлттэй болсон мэдээллүүдийг түр ч байна уу, сэтгүүлч нар ч байна уу. Хэн ч мэдээллийг цуглуулаад боловсруулах, ашиглах эрх нь хувь хүний мэдээлэл байгаа юм байна.

Тэгэхээр үүнээс гадна сэтгүүл зүйн зорилгоор тэр мэдээллийн эзний зөвшөөрөлтэйгөөр зөвшөөрөлгүй байсан ч сэтгүүл зүйн зорилгоор нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс бусад мэдээллийг бас цуглуулах эрх нь нээлттэй байгаа юм. Хязгаарлалттай мэдээлэл гэдэг дотор юуг хамааруулаад аваад үзээд байгаа юм бэ гэхээр ажлын хэсэг дээр ч ярьсан. 9.2.1, 9.2.2, 9.2.3 дээр байгаа үүнд бол ерөөсөө гэмт хэргийг зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад цуглуулж байгаа мэдээлэл хязгаартай байна. Гэхдээ энэ бол хаалттай биш. Зөвшөөрлөөр авч болно гэж байгаа. Прокурорын зөвшөөрлөөр олгож байгаа мэдээлэл байгаа шүү дээ. Мөн төрийн хяналт шалгалтын явцад шийдвэр хүчин төгөлдөр болгох хүртэл хугацаанд цуглуулсан мэдээлэл. Гэхдээ энийг хаагаагүй. Энэ бол тусгай тэр тухайн байгууллагынх зөвшөөрлөөр үзэж болно.

9.2.3 дээр нээлттэй болон соёлын хосгүй үнэт өвд аюул учруулж болзошгүй мэдээлэл. Энийг бол бас хязгаартайд тооцож байгаа. Тэрнээс биш зөвхөн нээлттэй байдлаар хэн хүссэнээр цуглуулаад боловсруулж ашиглаж бол болохгүй. Энэ гурван мэдээллийг бол зөвшөөрөлтэйгөөр одоо цуглуулж болно гэдгийг нээж өгсөн болохоос биш ерөөсөө хаалттай байдлаар хориглосон зүйл байхгүй.

Харин 9.2.4, 9.2.5 буюу анх энэ Засгийн газрын өргөн мэдүүлсэн хуулийн төсөл дээр бизнесийн нууцыг зөрчиж болзошгүй мэдээллийг мөн бас хязгаартай мэдээлэлд оруулсан байсан. Тэгээд бид ажлын хэсэг дээр яриад бизнесийн нууцыг зөрчинө гэдэг дотор энэ томьёолол маш олон мэдээллийг оруулаад ингээд мэдээллийг хязгаарлаад байх вэ гэдэг үүднээсээ энэ заалтыг хасаад хаясан. Хасаж хаях энэ саналыг оруулж ирж байгаа.

Дээрээс нь нөгөө оюуны өмчийн эрхээр баталгаажсан мэдээллүүд дээр оюуны өмчийн бүртгэлүүд чинь веб хуудсаараа нээлттэй байгаа учраас үүнийг энэ хязгаартайгаар оруулах шаардлагагүй юм байна. Яагаад гэхээр нийтийн нөгөө 67 мэдээлэл дотор чинь оюуны өмчийн байгууллага өөрөө тэр мэдээллүүдийг нийтэд нээлттэй болгох үүргийг хүлээж байгаа учраас энэ цуглуулж боловсруулах юм бүхэн нээлттэй байж байгаа. Тэгэхээр гишүүд юу хүсэх вэ гэхээр хязгаарлалттай мэдээлэл дотор бол энэ гурван төрлийн зүйл байгаа юм байна. Үүнийг тухайн одоо тэр хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны явцад цуглуулж байгаа мэдээллийг прокурорын зөвшөөрөлтэйгөөр тэр мэдээллийг цуглуулах эрх нь одоо нээгдэх ёстой. Тэрнээс биш хаасан зүйл бол огт байхгүй гэдгийг хэлмээр байна.

Хаалттай мэдээлэл дотроо бол бас одоо нөгөө төрийн нууцад хамааруулсан гэдгээрээ 10.1.2, 10.1.3 гэсэн гурван чиглэл байгаа. Тэрнээс биш энэ хууль гарснаараа бол илүү мэдээлэл ил тод болгох, нээлттэй болгох, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс иргэн болон бусад одоо этгээдүүд нийтийн ашиг сонирхлыг хамгаалах үүднээс мэдээлэл цуглуулах боловсруулах эрх нь нээгдэж байгаа гэдэг утгаараа бол маш том дэвшил авч ирж байгаа шүү л гэж хэлмээр байна.

С.Одонтуяа: Санал хураалт.

7 дугаар зүйлээр санал хурааж байна.

21 гишүүн дэмжиж, 53.8 хувийн саналаар дэмжигдлээ.

8.Төслийн 18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсгийн “Хуульд өөрөөр заагаагүй бол” гэснийг, 18.14 дэх хэсгийн “цахим хэлбэрээр” гэснийг тус тус хасаж, 18.16 дахь хэсгийн “гэрээний загвар,” гэсний дараа “зардал тооцох аргачлал,” гэж нэмж, 18.12 дахь хэсгийн “үндсэн системд холбогдсон мэдээллийн сангаас” гэснийг “үндсэн системээр дамжуулан” гэж 18.14, 18.15 дахь хэсгийн “үндсэн систем” гэснийг “үндсэн болон дэмжих систем” гэж тус тус өөрчилж, 18 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 18.2 дахь хэсэг нэмэх:

“18.2.Энэ хуульд заасан үндсэн систем, дэмжих систем, мэдээлэл хариуцагчийн систем нь нийтийн мэдээллийн системд хамаарна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

Оюунчимэг гишүүн.

М.Оюунчимэг: Учрал гишүүний тайлбарласан нэг зүйл дээр бол үнэхээр энэ хуульд орж байгаа бол маш зөв заалт орж байна. Албан байгууллагууд хувийн хэвшлийн компаниуд байгууллагын дотоод нууц гээд одоо зөрчилтэй хууль зөрчсөн элдэв буруу зөрүү юмнуудаа маш олон жил нууц ирсэн. Энэ бол бодит үнэ. Энэ өөрөө нөгөө хэвлэн нийтлэх мэдээлэл авах эрхэд бол ноцтой халдсан ийм зөрчил байсан. Хэрвээ энэ хуулиар үнэхээр энэ засагдаж орж ирж байгаа бол энэ бол дэвшил. Гэхдээ одоо энэ хувийн хэвшлийн зарим нэг компани жишээлбэл Оюутолгой компани гээд үзэхэд зарим нэг мэдээллээ уг нь бол тэр маш их хэрэгцээтэй. Улсын Их Хурлын гишүүн хүртэл энэ мэдээллийг бид авах хэрэгтэй байна гэхээр энэ бол байгууллагын нууц учраас тэд гаргаж өгч чадахгүй гэж хэлдэг. Сая та нар бизнесийн нууцыг зөрчинө гэдгээр зарим зүйлийг энд суулгахаа болиод авсан гэж байна л даа. Тэгэхээр энэ дээр ямар учиртай юм. Энэ нь өөрөө эргээд ухралд орчих вэ. Төрийн байгууллагууд л энийг буулгаж өгөх ёстой юм уу, эсвэл энэ хувийн хэвшлийн компаниуд энэ дээр бас хамт энэ хууль үйлчлээд явах уу.

Нэгдүгээрт энийг асуумаар байна.

Хоёрт нь энэ нэг нийтийн мэдээлэл хариуцагч нь өөрт байгаа мэдээллийг хүн хуулийн этгээдээс шаардлагагүй байх талаар хуулийн төслийн зарчимд нэмж тусгах гэсэн байна л даа. Энэ нь өөрөө тухайн үеийн бас шаардлагатай мэдээлэл байвал энийг тэгээд тухайн хүн нь үгүй гэвэл энэ нь гаргахгүй байх. Энэ нь бас нэг утгагүй ч юм шиг шаардлагагүй байна гэсэн байна л даа. Тэгэхээр энэ маань эргээд нөгөө нэг нээлттэй ил тод байдал гэдгээсээ зөрчилдөөд байгаа юм биш үү энэ хоёр чинь. Энэ хоёр дээр би нэг хариулт авахыг хүсэж байна, товчхон.

С.Одонтуяа: Энэ дэгээрээ саналаа хэлнэ. Асуулт хариулт бол байхгүй. Ирц хүрхээ больчихлоо гишүүд танхимдаа орж ирнэ үү. Ажлын хэсгийнхэн саяын Мөнхөөгийн Оюунчимэг гишүүний хэлсэн саналыг анхаарч тусгаарай.

Гишүүд танхимдаа орж ирнэ үү.

8 дугаар саналаар санал хураалт.

24 гишүүн дэмжиж, 61.5 хувиар санал дэмжигдлээ.

9 дүгээр санал. Төслийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсгийн “Нийтийн мэдээллийн системээр” гэснийг “Үндсэн системээр” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар.

Санал хураалт.

22 гишүүн дэмжиж, 56.4 хувиар санал дэмжигдлээ.

10.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь хэсгийг хасаж, 24.4 дэх хэсгийн “нэгдсэн системээс” гэснийг “нэгдсэн системээр дамжуулан мэдээлэл хариуцагчаас” гэж өөрчлөх санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

24 гишүүн дэмжиж, 61.5 хувиар санал дэмжигдлээ

11.Төслийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсгийн “Нийтийн мэдээллийн системийн” гэснийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт.

24 гишүүн дэмжиж, 61.5 хувиар санал дэмжигдлээ.

12.Төслийн 27 дугаар зүйлийн 27.10 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“27.10.Цахим хэлбэрээр үүсгэх нийтийн мэдээллийн сан нь нэгдсэн ангилал, код, тайлбартай байна.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

26 гишүүн дэмжиж, 63.4 хувиар санал дэмжигдлээ.

13.Төслийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийн “албан харилцаанд” гэснийг “хуульд заасан чиг үүргийн хүрээнд” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

27 гишүүн дэмжиж, 65.9 хувийн саналаар дэмжигдлээ.

14.Төслийн 32 дугаар зүйлийг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

27 гишүүн дэмжиж, 65.9 хувиар санал дэмжигдлээ.

15.Төслийн 33 дугаар зүйлийн 33.2 дахь хэсгийн “33.1.15-д” гэснийг “33.1.4, 33.1.13, 33.1.14, 33.1.15, 33.1.16, 33.1.18-д” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

25 гишүүн дэмжиж, 61 хувиар санал дэмжигдлээ.

16.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 34 дүгээр зүйлийн 34.5.3 дахь заалтын “түүхчилсэн бичлэг /лог/ үүсгэх” гэснийг “үйлдлийн бүртгэл үүсгэх” гэж өөрчилж, 34.5.4 дэх заалтыг хасах. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

25 гишүүн оролцож, 61 хувийн саналаар дэмжигдлээ.

17.Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалтын “нээлттэй өгөгдлийн нэгдсэн порталд” гэснийг “нээлттэй өгөгдлийн нэгдсэн системд” гэж өөрчилж, 35.1.8 дахь заалтын “өөрийн чиг үүрэгт хамаарах үйлчилгээг” гэсний дараа “цахим хэлбэрээр болон” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

25 гишүүн оролцож, 61 хувийн саналаар дэмжигдлээ.

18.Төслийн 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “2022 оны 6 дугаар сарын 01-ний өдрийн дотор” гэснийг “2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн дотор” гэж өөрчилж, 38.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“38.1.Энэ хуулийг дагаж мөрдөхөөс өмнө нийтийн мэдээллийн системийг ашиглан үйлчилгээ үзүүлж байгаа хуулийн этгээд цахим хөгжил, харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хугацаанд энэ хуульд заасан шаардлагыг хангах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.” Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

25 гишүүн оролцож, 61 хувийн саналаар дэмжигдлээ.

19.Төслийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсгийн “2021 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс” гэснийг “2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс” гэж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

26 гишүүн оролцож, 63.4 хувийн саналаар дэмжигдлээ.

20.Төслийн талаарх саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр томьёо, хэл найруулга, дэс дараалал, бүлэг, зүйл, заалтын дугаарыг нийцүүлж өөрчлөх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

24 гишүүн оролцож, 58.5 хувийн саналаар дэмжигдлээ.

Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжээгүй санал:

Төслийн нэрийг “Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Норовын Алтанхуяг, Сандагийн Бямбацогт, Цэрэнжамцын Мөнхцэцэг.

Бямбацогт гишүүн.

С.Бямбацогт: Баярлалаа. Тэгэхээр хуулийн төслийн нэрийг нийтийн мэдээллийн тухай гэсэн нэрийг нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль гэж нэрийг өөрчилсөн юм. Цөөнх болсон. 2011 онд Монгол Улсын Их Хурал мэдээллийн ил тод байдлын тухай гэж хууль баталсан. Энэ хуулийн шинэчилсэн найруулгыг нийтийн мэдээллийн тухай хууль болгож байгаа юм. Энэ хууль маань нийтдээ 39 зүйлтэй. 39 зүйлээс 2 хон зүйлээр, 9 дүгээр зүйлээр буруу мэдээллийг хязгаарлалттай болгож байгаа. 10 дугаар зүйлийг буруу мэдээллийг хаалттай болгож байгаа. Төрийн нууцтай холбоотой гэмт хэрэг зөрчилтэй холбоотой асуудлуудыг. Бусад зүйлүүд дээр үндсэндээ яавал мэдээллийг ил тод болгох вэ. Яавал нийт ард түмэнд одоо мэдээллийг нээлттэй байлгах вэ гэдэг л үзэл баримтлалыг агуулгад оруулна. Гэтэл агуулга нь одоо нөгөө хэлбэрээ илэрхийлэх үү, хэлбэр нь агуулгаа илэрхийлэх үү гэдэг дээр агуулга нь нийтэд мэдээллийг яавал ил тод байлгах вэ.

Хоёрхон зүйлээр хязгаарлах хаах мөртөө бусад зүйлээр 37 зүйлээр нээх гэж байгаа мөртөө нэр нь нийтийн мэдээллийн тухай гэгчхээд байгаа юм. Тийм болохоор нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль гэж нэрлэе гэсэн саналтай оруулсан юм.

Энэ хуулийн зорилго иргэний мэдээлэл хайх хүлээн авах эрхийг хангах. Мэдээллийг нээлттэй ил тод шуурхай байлгах. Төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилготой гэж хуулийн зорилго дээрээ биччихсэн. Хуулийн үйлчлэх хүрээ гэдэг дээрээ хуулиар төрийн нууцад хамааруулахаар зааснаас бусад мэдээллийг ил болгохтой холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна гэгчихсэн. Мөн зарчим дээр нь хуульд өөрөөр заагаагүй бол мэдээлэл ил тод нээлттэй байх ийм зарчим баримтална.

Мэдээллээр хангах үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагааг шуурхай хялбар байх ёстой. Мэдээлэл үйлчилгээ нь ойлгомжтой үнэн зөв бүрэн байх ёстой.

Нийтийн мэдээллийг ашиглах үйл ажиллагаанд хүн хуулийн этгээд эрх тэгш байх ёстой гэж. Өөрөөр хэлэх юм бол хуулийн зорилго үйлчлэх хүрээ энэ хуулийн зарчмууд нь үндсэндээ мэдээллийг яавал нээлттэй байлгах вэ. Өнөөдөр бодит байдал дээр төрийн мэдээлэл хаалттай гэдэг. Төрийн албан хаагчид мэдээлэл хаалттай, байгууллага хаалттай гээд өгдөггүй. Тэгвэл саяын хэлсэн хоёр, гуравхан зүйлээр 9, 10 дугаар зүйлийг хязгарлах, хаалттай болгох асуудал байгаа. Бусад

зорилго нь бол үндсэндээ нээлттэй болгох. Тийм болохоор хуулийн төслийн нэрийг нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай болгож өөрчилье гэж үндсэндээ агуулга хэлбэрээр илэрхийлье. Хуулийнхаа нэрийг өөрчилье гэсэн саналыг Алтанхуяг гишүүн Мөнхцэцэг гишүүд нар гаргасан юм. Энийг одоо манай гишүүд дэмжиж өгөөч. Агуулга хэлбэр нь бас зохицож байвал зөв байх гэж бодож байгаа юм.

Баярлалаа.

Дарахгүй гэсэн үг.

С.Одонтуяа: Байнгын хорооны дэмжээгүй саналыг дэмжье гэдэг томьёоллоор санал хураалт.

12 гишүүн дэмжиж, 29.3 хувиар дэмжсэн. 70.7 хувиар дэмжигдээгүй.

Тэгэхээр энэ гурван гишүүний гаргасан санал дэмжигдлээ гэсэн үг.

Учрал гишүүн.

Н.Учрал: Байнгын хороон дээр гишүүд ийм санал гаргасан. Гэхдээ энийг бас өмнө нь бид ажлын хэсэг дээр ярилцсан. Ер нь гаднын улсууд бол одоо тэр Испанийн хууль паблик инпормэшин акт гээд байдаг. Нийтийн мэдээллийн хууль гээд. Тэгэхээр энэ хууль чинь өөрөө зөвхөн ил тод байдлыг зохицуулах гэж байгаа хууль биш шүү дээ. Энэ хууль дотор чинь одоо зорилго дээр нь хүртэл энэ хуулиар нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн орчныг бүрдүүлж байгаа юм. Одоо энэ үндсэн систем гэж юу юм. Үйлчилгээний нэгдсэн систем гэж юу юм. Энэ бүрийг чинь бүгдийг нь нь хуульчилж өгсөн. Дэд бүтцийг нь нь тодорхой болгож байгаа юм бүхэлдээ. Мөн төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр яаж явуулах, ил тод түргэн шуурхай байлгах, Төрийн үйл ажиллагаанд хяналтыг бий болгох гээд цогцоор нь харсан харилцааг зохицуулж байгаа хууль байхад хэрвээ мэдээллийн ил тод байдлын хууль гэх юм бол энэ чинь яг одоо тэр хэвлэлийн эрх чөлөөний хууль ч юм уу, эсвэл одоо тэр мэдээлэл авах эрхийн тухай, мэдээллийн ил тод байдлын тухай өөр ойлголт болчихно. Тэгэхээр энэ нийтийн мэдээллийн хууль дотор чинь мэдээллүүдээ бид нар чинь ангилаад тэр 67-гоо нээлттэй болгоод. Хаалттайд нь ямар мэдээллүүд байх вэ. Тодорхой зөвшөөрөлтэйгөөр цуглуулах эрхтэй тэр гурван төрлийн хязгаарлалттай мэдээлэл байна.

Эдгээрийг дэд бүтцүүдийг нь хэрхэн хөгжүүлэх вэ. Одоо нөгөө e.mongolia гээд ярьж байгаа. Энэ төрийн үйлчилгээний нэгдсэн систем чинь тэр хур гээд байгаа үндсэн систем чинь хэрхэн хэрэгжих вэ гээд бүхэлдээ хатуу болон зөөлөн дэд бүтцийг хуульчилж өгч байгаа юм. Тэгэхээр энэ хуулиар дамжуулаад төрийн үйл ажиллагаа цахимжих. Цаашлаад нөгөө Кибер аюулгүй байдлын хуультайгаа хүртэл уялдах гээд томоохон ойлголт бол явж байгаа. Тэгэхээр яг тэр паблик инпормешин гэдэг нэрээрээ нийтийн мэдээллийн хууль гээд явахгүй бол ил тод байдлын хууль гэх юм бол энэ чинь зорилгын хувьд өөр чиглэл рүү явчих юм.

Тийм учраас бол зүгээр яах вэ харагдах төдийд биш цаашдаа энэ хуулийг хэрэгжүүлж ажиллах бас энэ гүйцэтгэх засаглалаа хүндэтгээд бид нар бол нийтийн мэдээллийн хуулиа баталж өгөх ёстой байх гэж бодож байна.

Өмнө нь энэ хууль 2019 онд бас орж ирэхдээ Цахим харилцааны хууль гээд, цахим засаглалын хууль гээд янз бүрийн нэршилтэй орж ирж байсан. Тэгээд цахим харилцааны хууль гэхээр энэ чинь зөвхөн цахим орчин дахь асуудал биш шүү дээ.

Энэ чинь эргээд эцэстээ нийтэд ямар мэдээлэл ил тод байхыг гаргаж өг гэж байгаа. Ямар мэдээлэл хаалттай байхыг гаргаж өгч байгаа. Дэд бүтцийг нь хуульчилж байгаа учраас энэ цахим засаглалын ч хууль биш юм байна. Тийм учраас хамгийн зөв нэр томъёо нь бол нийтийн мэдээллийн хууль юм байна гээд бид одоо бас тэр үед саналаа хэлж байсан. Ингээд Засгийн газрын нийтийн мэдээллийн хууль гээд энэ хуулийг оруулж ирж байгаа юм.

Нэршлийн хувьд бол ил тод байдлын хууль гэж яав ч болохгүй байгаа юм. Дотроо зохицуулалт нь зорилго нь өөр зүг рүү явчхаж байгаа юм. Ил тод байдал гэх юм бол.

Тийм саналтай байгаа шүү. Би түрүүн тэгээд үгээ хэлье гээд байсан, хэлүүлэхгүй.

Би одоо зарчмын зөрүүтэй санал гаргая.

С.Одонтуяа: Хариулт гэж байхгүй. Гишүүд саналаа хэлж байгаа. Саяын Бямбацогт гишүүний асуултад. Одоо сая бол Бямбацогт гишүүний санал дээр Учрал гишүүн хариулт өгөөд байгаа байхгүй юу.

Асуулт хариултын дэг бол байхгүй. Тийм учраас сая бол санал хураасан. Асууж хариулах дэг байхгүй учраас.

Н.Учрал: Ядаж нийтийн мэдээллийн ба одоо мэдээллийн ил тод байдлын хууль ч гэдэг юм уу. Тэгэхгүй юм бол дан мэдээллийн ил тод байдал биш шүү дээ.

С.Одонтуяа: Байнгын хороон дээрээ эцэслээд хэлэлцэх чиглэл өглөө.

Хоёр.Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн найруулгын саналаар санал хураана.

Төслийн 4 дүгээр зүйлийн 4.1.11 дэх заалтын “мэдээллийн системийн тусламжтайгаар” гэснийг “мэдээллийн системийг ашиглан” гэж, 8 дугаар зүйлийн 8.2.2 дахь заалт, 9 дүгээр зүйлийн 9.6.2, 9.6.3 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.2.1 дэх заалтын “харилцах утас” гэснийг “харилцах утасны дугаар” гэж, 8 дугаар зүйлийн 8.2.10 дахь заалтын “зохион явуулах” гэснийг “зохион байгуулах” гэж, 8.4.14 дэх заалтын “олон улсын байгууллагаас авах зээл” гэснийг “олон улсын байгууллагаас авсан зээл” гэж, 9.15 дахь хэсгийн “баталгаа” гэснийг “баталгаажуулалт” гэж, 9 дүгээр зүйлийн 9.17 дахь хэсгийн “үйл ажиллагааны болон” гэснийг “үйл ажиллагаа,” гэж, 36 дугаар зүйлийн 36.2.5 дахь заалтын “нэвтрэлт хийгдсэн” гэснийг “нэвтэрсэн” гэж тус тус өөрчлөх.

2.Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалтын “мэдээлэл хариуцагч,” гэснийг хасах.

3.Төслийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсгийн “ил тод, нээлттэй” гэсний өмнө “байнга” гэж, 9 дүгээр зүйлийн 9.2.3 дахь заалтын “соёлын хосгүй” гэсний дараа “үнэт” гэж, 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсгийн “холбогдсон харилцааг” гэсний дараа “тухайлсан” гэж тус тус нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

27 гишүүн дэмжиж, 65.9 хувиар найруулгын санал дэмжигдлээ.

Нийтийн мэдээллийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн талаар ажлын хэсгээс гаргасан саналын томьёолол.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол.

Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн санал.

Төслийн 1, 2 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

1 дүгээр зүйл.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.13 дахь заалтын “Цахим гарын үсгийн тухай хуулийн 4.1.4-т заасныг” гэснийг “Нийтийн мэдээллийн тухай хуулийн 4.1.9-д заасныг” гэж, 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсгийн “мөрдөнө” гэснийг “мөрдөж болно” гэж, 38 дугаар зүйлийн 38.2 дахь хэсгийн “тоон гарын үсгээр” гэснийг “цахим гарын үсэг, эсхүл давтагдашгүй дугаараар” гэж тус тус өөрчилсүгэй. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

25 гишүүн дэмжиж, 61.0 хувиар санал дэмжигдлээ.

2. Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн талаарх саналын томьёолол.

Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хорооны дэмжсэн санал.

Төслийн 1 дүгээр зүйлийн “15.33 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хязгаарлалттай мэдээллийг” гэсний өмнө “Албаны нууцаас бусад” гэж нэмэх. Санал гаргасан ажлын хэсэг.

Санал хураалт.

27 гишүүн дэмжиж, 65.9 хувиар санал дэмжигдлээ.

Зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хурааж дууслаа.

Нийтийн мэдээллийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн болон Инновац, цахим бодлогын байнгын хороонд шилжүүлэв.

Өнөөдрийн нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх асуудал дууссан тул хуралдаан өндөрлөснийг мэдэгдье.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

П.МЯДАГМАА